ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Завхан аймгийн "Очир-Илч" ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан.

**Аудитын код:** ЗАА-2024/07/НА-СТА-ТШЗ

---

Цахим хуудас: www.audit.mn
Улиастай сум
2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn
Аудитор: Б.Мөнхнасан
Утас: 90066888
Цахим хаяг: munkhnasanb@audit.gov.mn

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
   2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
   2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
   2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
   2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
   2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....8
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан....13
   4.1 Ерөнхий зүйл ....13
   4.2 Материаллаг байдал ....14
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....14
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....16
5. Аудитын илрүүлэлт ....16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс 7046-36 12
Цахим шуудан: zavkhan@audit.gov.mn

2024.03.15 № 244

танай ..... -ны № ..... -т

"ОЧИР-ИЛЧ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ц.НОРОВСАМБУУ-Д

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Очир-Илч" ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Очир-Илч" ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

"Очир-Илч" ХХК-ийн үндсэн үйл ажиллагааны орлого 341,988.3 мянган төгрөгийн бүрдүүлэлт зарцуулалтыг үзсэн бөгөөд тус байгууллагын өглөг болон авлагын барагдуулалтын гүйцэтгэлийг онцолсон.

**Аудитын гол асуудал**

"Очир-Илч" ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

"Очир-Илч" ХХК-ийн үйл ажиллагааны мөнгөн орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн зарцуулсан, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-ҮНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | оны 12-р сарын 31 2022 | оны 12-р сарын 31 2023 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 1,934,561.97 | 5,130,282.17 |
| 1.1.2 | Дансны авлага | 26,637,764.00 | 23,572,164.00 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | 0.01 | 0.01 |
| 1.1.6 | Бараа материал | 4,084,848.82 | 13,178,496.91 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **32,657,174.80** | **41,880,943.09** |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 1,806,031,859.00 | 1,752,603,371.13 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 250,000.00 | 250,000.00 |
| 1.2.10 | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **1,806,281,859.00** | **1,752,853,371.13** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,838,939,033.80** | **1,794,734,314.22** |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 49,669,922.36 | 42,102,038.00 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 12,384.57 | 0.00 |
| 2.1.1.3 | Татварын өр | 9,512,490.85 | 31,909,826.41 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | 1,976,542.60 | |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр | 154,179,931.00 | 154,179,931.00 |
| 2.1.1.13 | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **215,351,271.38** | **228,191,795.41** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **215,351,271.38** | **228,191,795.41** |
| 2.3.2 | - хувийн | 1,763,569,800.00 | 1,763,569,800.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 986,903,906.00 | 986,903,906.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | -1,126,885,943.58 | -1,183,931,187.19 |
| 2.3.11 | **Эздийн өмчийн дүн** | **1,623,587,762.42** | **1,566,542,518.81** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **1,838,939,033.80** | **1,794,734,314.22** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | оны 12-р сарын 31 2022 | оны 12-р сарын 31 2023 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **236,980,142.97** | |
| 3 | **Нийт ашиг ( алдагдал)** | **236,980,142.97** | |
| 4 | Түрээсийн орлого | | 317,834,543.00 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 313,174,114.85 | 365,150,883.41 |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 2,263,994.01 | 9,253,085.02 |
| 11 | Санхүүгийн зардал | | 294,000.00 |
| 12 | Бусад зардал | | 181,818.18 |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)** | **-78,457,965.89** | **-57,045,243.61** |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **-78,457,965.89** | **-57,045,243.61** |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **-78,457,965.89** | **-57,045,243.61** |
| **24** | **Орлогын нийт дүн** | **-78,457,965.89** | **-57,045,243.61** |
| **25** | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)** | | |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | оны 12-р сарын 31 | оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| | | 2022 | 2023 |
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1 | Мөнгөн орлогын дүн (+) | 257,915,447.00 | 341,988,337.61 |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 257,915,447.00 | 24,153,794.61 |
| | Бусад мөнгөн орлого | | 317,834,543.00 |
| 1 | Мөнгөн зарлагын дүн (-) | 188,017,092.77 | 235,982,027.36 |
| | Ажиллагчдад төлсөн | 79,770,747.00 | 113,082,718.16 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 20,892,065.03 | 34,851,905.91 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 13,900,901.46 | 19,859,190.45 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 19,991,820.09 | 37,744,848.18 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 999,994.46 | 104,972.73 |
| | Татварын байгууллагад төлсөн | 32,761,977.03 | 7,143,640.14 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | | 87,340.00 |
| | Бусад мөнгөн зарлага | 19,699,587.69 | 23,107,411.79 |
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **69,898,354.23** | **106,006,310.25** |
| 2 | Мөнгөн орлогын дүн (+) | 6,792,880.00 | 3,065,600.00 |
| | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 6,792,880.00 | 3,065,600.00 |
| 2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 1,220,400.00 | 8,754,454.55 |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | 3,524,454.55 |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 250,000.00 | |
| | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 970,400.00 | 5,230,000.00 |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **5,572,480.00** | **-5,688,854.55** |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Мөнгөн зарлагын дүн (-) | 76,111,363.64 | 97,121,735.49 |
| | Зээл, орийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 76,111,363.64 | 97,121,735.49 |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-76,111,363.64** | **-97,121,735.49** |
| **5** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **-640,529.41** | **3,195,720.21** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,575,091.37** | **1,934,561.97** |
| **7** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **1,934,561.97** | **5,130,282.17** |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| № | ҮЗҮҮЛЭЛТ | | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | оны -р сарын -ний үлдэгдэл | 2021 | 1,763,569,800.00 | 986,903,906.00 | -1,048,454,867.29 | 1,702,018,838.71 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | 26,889.60 | 26,889.60 |
| 3 | Залруулсан үлдэгдэл | | 1,763,569,800.00 | 986,903,906.00 | -1,048,427,977.69 | 1,702,045,728.31 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | -78,457,965.89 | -78,457,965.89 |
| 9 | оны -р сарын -ний үлдэгдэл | 2022 | 1,763,569,800.00 | 986,903,906.00 | -1,126,885,943.58 | 1,623,587,762.42 |
| 11 | Залруулсан үлдэгдэл | | 1,763,569,800.00 | 986,903,906.00 | -1,126,885,943.58 | 1,623,587,762.42 |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | -57,045,243.61 | -57,045,243.61 |
| 17 | оны -р сарын -ний үлдэгдэл | 2023 | 1,763,569,800.00 | 986,903,906.00 | -1,183,931,187.19 | 1,566,542,518.81 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн "Очир-Илч" ХХК нь гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

***Завхан аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын үндсэн чиг үүрэг:***

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлын түвшинг бууруулах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төсөвлөлт, зарцуулалт, тайлагналтыг ил тод, нээлттэй болгож, хяналтыг сайжруулах;
- Бодлогын хэрэгжилтийн явц, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төлөвлөлт, гүйцэтгэл, үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх;

Байгууллагын 2023 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:***

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

***Байгууллагын дотоод хяналтын талаар:*** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын зөвлөл нь 2023 оны ажлын төлөвлөгөөндөө 5 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт бүрд удирдамж батлуулж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн "Очир-Илч" ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн "Очир-Илч" ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,204.7 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар буурсан байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|

| Б | 1 | 2 | 3=2-1 |
|---|---|---|---|
| Авлага | 26,637.7 | 23,572.1 | (3,065.6) |
| Бараа материал | 4,084.8 | 13,178.4 | 9,093.6 |
| Үндсэн хөрөнгө | 1,806,031.0 | 1,752,603.3 | (53,427.7) |
| **Нийт хөрөнгө** | **1,838,939.0** | **1,794,734.3** | **(44,204.7)** |
| Өр төлбөр | 49,669.9 | 42,102.0 | (7,567.9) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,838,939.0** | **1,794,734.3** | **(44,204.7)** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Бараа материал эхний үлдэгдэл 4,084.8 мянган төгрөг, өөрийн орлогоор худалдан авсан 18,959.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 9,865.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 13,178.4 мянган төгрөг болсон байна.

Үндсэн хөрөнгийн хувьд 4,524.5 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу нэмэгдэж, жилийн эцэст 1,752,603.3 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 113,116.0 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг түрээсийн орлогын 317,834.5 мянган төгрөг, нийт зарлагыг 365,150.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Гүйцэтгэлээр 317,834.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 100 хувьтай зарцуулсан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилт байхгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Байхгүй | | | |
| 2 | Байхгүй | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Байхгүй | | | |
| **ДҮН** | | | **0** | **0** |

Тайлант оны худалдан авах ажиллагаатай холбоотой ажил үйлчилгээ явагдаагүй байна..

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Завхан аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Б.Мөнхнасан гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Болдбаатар, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн "Очир-Илч" ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугээр сарын 25-ны өдрийн 29 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгийн 1,794,734.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 26,921.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 20,190.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 20 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн "Очир-Илч" ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, албан шаардлага өгөгдөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өглөг болон авлагын барагдуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

*Аудитаар алдаа зөрчил илрээгүй тул бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтрэх алдаагүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.*

### 5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

### 5.2 Албан шаардлага өгөгдөөгүй

### 5.3 Зөвлөмж өгөгдөөгүй

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| | Нийт зөрчил | Үүнээс |
|---|---|---|

| Зөрчлийн товч утга | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР Б.МӨНХНАСАН

Огноо: 2024-03-25